



СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК  
(Хувьцааны код: CUMN)

### ХУРАЛД ОРОЛЦОХООР БҮРТГҮҮЛЭХ, ЦАХИМААР САНАЛ ӨГӨХ ЗААВАР

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК (“Компани”)-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“Хурал”)-ыг 2021 оны 12-р сарын 28-ны өдрийн 10:00 цагт <https://hural.cumongol.mn> веб хаягаар Zoom платформ ашиглан цахим хэлбэрээр хуралдуулна.

2021 оны 12-р сарын 10-ны өдрийн байдлаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд Компанийн хувьцаа эзэмшигчээр бүртгэлтэй байгаа хувьцаа эзэмшигчид тус Хуралд оролцох эрхтэй байна. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн цахим бүртгэл 2021 оны 12-р сарын 15-ны өдрийн 10:00 цагаас эхлэн 2021 оны 12-р сарын 25-ны өдрийн 16:00 цаг хүртэл хийгдэнэ. Хувьцаа эзэмшигч нь дараах журмаар хуралд оролцохоор бүртгүүлнэ.

Компанийн хувьцаа эзэмшигч байгууллагын хувь Хуралд оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилсон байх шаардлагатай бөгөөд тус итгэмжлэгдсэн төлөөлөгчид холбогдох нотариатаар баталгаажсан итгэмжлэлийг олгосон байна. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь итгэмжлэлийн дагуу дараах журмаар хуралд оролцохоор бүртгүүлнэ.

1. <https://hural.cumongol.mn> веб хаягт хандан орж харгалзах талбарт өөрийн дараах мэдээллийг оруулж Хуралд оролцох хүсэлт ээ илгээнэ.
  - Овог, нэр;
  - Регистрийн дугаар (*гадаад хувьцаа эзэмшигчийн хувьд*: паспортын дугаар);
  - Утасны дугаар;
  - Цахим шуудангийн хаяг;
  - Иргэний үнэмлэхийн нүүр болон ар талын зураг (*16-с доош насны иргэний хувьд*: төрсний гэрчилгээний зураг, *гадаад иргэний хувьд*: паспортын зураг);
  - *Байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд* итгэмжлэлийн зураг.
2. Хувьцаа эзэмшигчийн илгээсэн мэдээллийг Хурал зохион байгуулах комисс Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн жагсаалттай тулган баталгаажуулна.
3. Хувьцаа эзэмшигчийн баталгаажуулалт амжилттай болсон тохиолдолд дараах мэдээлэл хувьцаа эзэмшигчийн бүртгэлтэй утасны дугаарт мессежээр ирнэ.
  - Бүртгэл амжилттай хийгдсэн тухай баталгаажуулалт;
  - Цахим хуралд оролцох линк;
  - <https://hural.cumongol.mn> веб хаягт цахимаар санал өгөхөд нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг.

### ХУРАЛД ЦАХИМААР САНАЛ ӨГӨХ

Цахимаар санал өгөхөд нэвтрэх нэр, нэвтрэх нууц үгийг хүлээн авсан Хувьцаа эзэмшигч дараах 3 аргаас сонгон санал өгөх боломжтой. Үүнд:

- (А) Урьдчилан цахимаар санал өгөх. Хурлын урьдчилсан санал хураалтыг <https://hural.cumongol.mn> веб хаягаар 2021 оны 12-р сарын 16-ны өдрийн 10:00 цагаас эхлэн 2021 оны 12-р сарын 26-ны өдрийн 16:00 цаг хүртэл хүлээн авна.

- (Б) Хурлын үеэр цахимаар санал өгөх. Хурлын үеэр буюу 2021 оны 12-р сарын 28-ны өдрийн 10:00 цагт <https://hural.cumongol.mn> веб хаягт хандан санал өгөх.
- (В) Хурлын шууд нэвтрүүлэлт хийж буй газарт хүрэлцэн ирж цахимаар санал өгөх. Энэ тохиолдолд хувьцаа эзэмшигч нь 2021 оны 12-р сарын 28-ны өдрийн 10:00 цагт Монгол Улс, Улаанбаатар хот 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19А, Шангри-Ла Худалдааны Төв, 4-р давхарт, Өргөө 3 кино театр, 4-р танхимд биечлэн ирж <https://hural.cumongol.mn> веб хаягт хандан санал өгөх.

Цахимаар санал өгөхөд нэвтрэх нэр, нэвтрэх нууц үгийг хүлээн авсан Хувьцаа эзэмшигч дараах журмаар санал аа өгнө.

1. <https://hural.cumongol.mn> веб хаягт хандана.
2. Бүртгэлтэй утасны дугаарт ирсэн нэвтрэх нэр, нууц үгийг харгалзах талбарт оруулан системд нэвтэрнэ.
3. Хурлаар хэлэлцэж буй 1-3 дах асуудал тус бүрийн харгалзах хэсэгт “Зөвшөөрсөн”, “Татгалзсан” эсвэл “Түдгэлзсэн” гэдгээ илэрхийлж аль нэгийг сонгон  тэмдэглэгээг хийж санал аа өгнө.  
  
Хурлаар хэлэлцэж буй 4 дэх асуудлын хувьд санал хураалтыг кумулятив аргаар хураана. Хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн 1 хувьцаа нь 9-н саналын эрхтэй байх ба хувьцаа эзэмшигч саналын нийт эрхээ өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй. Ийнхүү санал аа өгөхдөө харгалзах талбарт саналын тоог оруулах хэлбэрээр өгнө.
4. Санал өгөх талбарын доод хэсэгт байрлах Анхааруулга хэсэгт  тэмдэглэгээг хийснээр “САНАЛ ӨГӨХ” товчлуур идэвхэжнэ.
5. “САНАЛ ӨГӨХ” товчлуур дээр дарж санал аа илгээнэ.
6. Санал тоологдсоныг баталгаажуулсан цонх гарч ирнэ.